



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 137

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөр Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн хичээлийн 1 дүгээр байранд хийсэн нийт 222,232,247.00 (хоёр зуун хорин хоёр сая хоёр зуун гучин хоёр мянга хоёр зуун дөчин долоон) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан их засвар, дотор инженерийн шугам сүлжээний ажлыг тус сургуулийн үл хөдлөх хөрөнгийн холбогдох дансанд капиталжуулан бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн захирлын үүрэг гүйцэтгэгч М.Должинд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөр бий болсон хавсралтад заасан хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтаар хүлээн авах;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-г үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



З.МЭНДСАЙХАН

Д.НАРАНГЭРЭЛ

000133

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2020 оны 04 дугаар сарын 01-ний өдрийн  
137... дугаар тогтоолын хавсралт

**ХУДАЛДАА ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИХ СУРГУУЛИЙН ҮНДСЭН  
ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ИХ ЗАСВАРЫН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ
1	Хэрэглээний халуун усны ялтсан бойлерыг солих, дотор сантехникийн их засвар	багц	1	65,309,305.00
2	Дотор засвар	багц	1	79,641,362.00
3	Дотор инженерийн шугам сүлжээний засвар	багц	1	77,281,580.00
			3	222,232,247.00
	Нийт дүн			(хоёр зуун хорин хоёр сая хоёр зуун гучин хоёр мянга хоёр зуун дөчин долоо)